

## ИНФЛЮЗЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Өнөөдөр бид дижитал шилжилтийн эрин үед амьдарч байна. Иргэдийн мэдээлэл авах, бараа үйлчилгээ сонгох, санхүүгийн шийдвэр гаргах, нийгмийн үзэл хандлага бүрэлдэх үйл явц улам бүр сошиал сүлжээ, цахим платформ руу шилжиж байна. Энэхүү өөрчлөлтийн төвд инфлюзер буюу цахим орчинд олон нийтийн нөлөө бүхий контент бүтээгчид орж байна.

Facebook, YouTube, TikTok, Instagram зэрэг платформ дээр үйл ажиллагаа явуулдаг инфлюзерүүд өнөөдөр хэдэн зуун мянгаас сая хүртэлх хэрэглэгчидтэй шууд харилцаж, хэрэглэгчийн зан төлөв, худалдан авалтын шийдвэр, тэр ч байтугай нийгмийн хандлагад хүчтэй нөлөөлөх боллоо.

Монгол Улсад ч энэхүү зах зээл эрчимтэй тэлж байна. Сүүлийн жилүүдэд бизнесүүд уламжлалт телевиз, хэвлэлээс илүүтэйгээр сошиал платформ дахь сурталчилгаанд хөрөнгө оруулах болсон бөгөөд инфлюзер маркетинг нь худалдаа, гоо сайхан, эрүүл мэнд, боловсрол, аялал жуулчлал, криптовалют, санхүүгийн үйлчилгээ зэрэг олон салбарт түгээмэл хэрэглэгдэж байна.

Гэвч энэхүү хурдацтай өсөлттэй зэрэгцэн хууль эрх зүйн зохицуулалтын тодорхойгүй байдал бодит эрсдэлүүдийг бий болгож байна.

Нэгдүгээрт, төлбөртэй сурталчилгааг хэрэглэгчээс нуун далд хэлбэрээр нийтлэх явдал түгээмэл болж байна. Хэрэглэгч тухайн контент нь бодит хэрэглээний туршлага уу, эсвэл төлбөртэй маркетинг уу гэдгийг ялгах боломжгүй нөхцөл үүсэж байна. Монгол Улсад зарим инфлюзерүүд бараа бүтээгдэхүүн, эмчилгээ үйлчилгээ, онлайн худалдаа, санхүүгийн платформыг “өөрөө хэрэглээд үр дүн гарсан” гэх хэлбэрээр сурталчилдаг боловч тухайн агуулга нь төлбөртэй сурталчилгаа байсан нь дараа нь ил болсон тохиолдлууд олон нийтийн шүүмжлэл дагуулж эхэллээ.

Хоёрдугаарт, баталгаагүй эрүүл мэндийн бүтээгдэхүүн, эмчилгээ, биологийн идэвхт бүтээгдэхүүн, түргэн тураах бүтээгдэхүүн, арьс гоо заслын үйлчилгээ, мөн өндөр эрсдэлтэй хөрөнгө оруулалт, криптовалют, форекс, онлайн мөрийтэй тоглоомын шинжтэй платформуудыг инфлюзерүүдээр дамжуулан сурталчлах тохиолдол нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, олон улсын хэмжээнд АНУ-д алдартай инфлюзерүүд болон олны танил хүмүүс криптовалютын төслүүдийг сурталчилсны улмаас хэрэглэгчид их хэмжээний хохирол амссан асуудлууд гарч байсан бөгөөд АНУ-ын Үнэт цаас, биржийн хорооноос (SEC) зарим инфлюзерүүдэд торгууль ногдуулсан байдаг. Манайд яг иймэрхүү тохиолдол бүртгэгдэж хууль хяналтын байгууллагад шилжсэн тухай мэдээлэл байдаг. Франц улс 2023 онд инфлюзерийн үйл ажиллагааг зохицуулах тусгай хууль баталж, криптовалют, гоо сайхны мэс засал, никотин агуулсан бүтээгдэхүүн зэрэг өндөр эрсдэлтэй сурталчилгаанд хатуу хязгаарлалт тогтоосон байна.

Гуравдугаарт, хүүхэд болон өсвөр насныханд чиглэсэн зохисгүй маркетинг нэмэгдэж байна. Хүүхдийн сэтгэл зүй, шийдвэр гаргах чадвар бүрэн төлөвшөөгүй байдлыг ашиглан худалдан авалтад шууд уриалах, хэт хэрэглээг өдөөх, насанд тохироогүй бүтээгдэхүүн сурталчлах асуудал сошиал орчинд түгээмэл ажиглагдаж байна. Их Британи болон Европын холбооны орнуудад хүүхдэд чиглэсэн инфлюзер

маркетингт тусгай хязгаарлалт тавьж, тодорхой төрлийн сурталчилгааг хориглох бодлого хэрэгжүүлж эхэлсэн.

Дөрөвдүгээрт, хуурамч дагагч, хиймэл үзэлт, автомат сэтгэгдэл ашиглан хэрэглэгч болон бизнес эрхлэгчдийг төөрөгдүүлэх асуудал нэмэгдэж байна. Энэ нь шударга өрсөлдөөнийг алдагдуулж, сурталчилгааны зах зээлийн үнэлгээг хиймлээр өсгөх эрсдэл бий болгож байна. Одоогийн байдлаар дээрх асуудлыг Зар сурталчилгааны тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон холбогдох бусад хуулиар хэсэгчлэн зохицуулж байгаа боловч инфлюзерийн үйл ажиллагааны онцлог, цахим платформын шинэ харилцаанд нийцсэн тусгай зохицуулалт хангалтгүй байгаа юм.

Иймд инфлюзерийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хүүхэд болон эмзэг бүлгийг хамгаалах, цахим орчин дахь шударга өрсөлдөөнийг дэмжих зорилгоор “Инфлюзерийн үйл ажиллагааг зохицуулах тухай” хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах үндсэн зохицуулалтуудыг тусгасан болно. Үүнд:

Нэгдүгээрт, инфлюзерийн эрх зүйн статус, үйл ажиллагааны ангилал, тодорхой шалгуурыг хуульчилж, мэргэжлийн түвшний үйл ажиллагаанд тодорхой бүртгэлийн тогтолцоо бий болгоно.

Хоёрдугаарт, төлбөртэй сурталчилгаа, ивээн тэтгэлэг, бэлэг, бартер, affiliate холбоос зэрэг арилжааны агуулгыг хэрэглэгчид шууд танихуйц байдлаар тодорхой тэмдэглэх үүргийг хуульчилна.

Гуравдугаарт, хэрэглэгчийг төөрөгдүүлэх худал мэдээлэл, баталгаагүй эрүүл мэндийн бүтээгдэхүүн, өндөр эрсдэлтэй санхүүгийн сурталчилгаанд тусгай шаардлага, хязгаарлалт тогтооно.

Дөрөвдүгээрт, хүүхэд болон эмзэг бүлгийг хамгаалах тусгай зохицуулалт бий болгож, хүүхдэд чиглэсэн зарим төрлийн маркетинг, худалдан авалтад шууд уриалсан агуулгыг хориглоно.

Тавдугаарт, инфлюзер, сурталчилгааны захиалагч, агентлаг болон платформын эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, гэрээ болон төлбөрийн харилцааны ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

Олон Улсын туршлагаас харахад инфлюзерийн зах зээл нь зөвхөн маркетингийн шинэ хэлбэр бус, хэрэглэгчийн эрх, мэдээллийн аюулгүй байдал, шударга өрсөлдөөнтэй шууд холбоотой шинэ төрлийн зохицуулалтын салбар болж байна. Тухайлбал:

- Франц улс 2023 онд инфлюзерийн үйл ажиллагааны тухай тусгай хууль баталсан;
- АНУ-д Холбооны худалдааны комисс (FTC) төлбөртэй сурталчилгаанд заавал disclosure хийх стандартыг мөрдүүлж байна;
- Их Британи улсын Advertising Standards Authority (ASA) инфлюзерийн сурталчилгаанд тусгай хяналт тавьдаг;
- Европын холбоо Digital Services Act-ийн хүрээнд платформын ил тод байдлыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж байна.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар:

- сошиал орчин дахь сурталчилгаа илүү ил тод болох;
- хэрэглэгчийн эрхийг хамгаалах хамгаалалт сайжирах;
- хүүхэд, өсвөр үеийнхнийг цахим орчны зохисгүй нөлөөллөөс хамгаалах;
- шударга өрсөлдөөнийг дэмжих;
- инфлюзерийн зах зээлийг илүү хариуцлагатай, мэргэжлийн түвшинд хөгжүүлэх;
- цахим эдийн засгийн шинэ орчны эрх зүйн суурийг бэхжүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

ГАРЫН ҮСЭГ

--- оОо ---